



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2015.08.31. № 448.

танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ
МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Б.БАДРАЛ ТАНАА

Санхүүгийн тайлангийн аудитын гэрчилгээ,
аудитыг дуусгавар болгосон тухай тайланг хүргүүлж
байна.

Хавсралт ²² хуудас

ДЭД ДАРГА



Т.САРАНТУЯА



1110400448



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2015.03.31. № 449.
танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ
МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Б.БАДРАЛ ТАНАА

АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн Аудитын газраас аудит хийв.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн Аудитын газар нь Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Нийслэлийн Аудит газар нь Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц. ОЧИРБАТ

УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

Аудитын тайлан

Т.Сарантуяа

Нийслэлийн аудитын
газрын дэд дарга
өрөөний утас: 327744

Д.Энхдалай

Санхүүгийн аудитын
менежер
өрөөний утас: 315558

Т.Наранчимэг

Багийн ахлах аудитор

Б.Мөнхбат

аудитор
өрөөний утас: 325093

ТАБ-ын хаяг: Нийслэлийн
аудитын газар

Байршил: Улаанбаатар
хот Сүхбаатар дүүрэг,
Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг
захиргааны V байр

E mail: ub@audit.mn

Вэб: www.city.audit.mn

Агуулга

Хавсралт 1: Менежментийн захидал

Хавсралт 2: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 3: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Хавсралт 4: Аудитлагдсан төсвийн
гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.2-д заасан Нийслэлийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд УБ хотын Захирагчийн ажлын албаны 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /НАГ-АХ/2015/-СА-I-2-17/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

УБ хотын Захирагчийн ажлын албаны 2014 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

УБ хотын Захирагчийн ажлын албаны 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 2 дугаар сарын 25-наас 2015 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн Нийслэлийн аудитын газрын СА-ын I албаны 2 багийн аудитор Б.Мөнхбат 2015 оны 3 дугаар сарын 5-наас 3 дугаар сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлан, гэрчилгээг 2015 оны 3 дугаар сарын 25нд УБ хотын Захирагчийн ажлын албаны удирдлагад хүргүүлэв.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

УБ хотын Захирагчийн ажлын албаны төсвийн захирагч нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд Засгийн газрын 333 дугаар тогтоол Төрийн зарим албан хаагчдийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай, Засгийн газрын 147 дугаар тогтоол Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай шийдвэрүүд шинээр гарсан байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Хүний нөөцийн удирдлага, манлайллыг хэрэгжүүлэн Нийслэлчүүдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан төрийн үйлчилгээний шуурхай байдал, чанар хүртээмжийг нэмэгдүүлж, иргэн бүрийн сэтгэл ханамжийг бий болгоход оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу УБ хотын Захирагчийн ажлын албаны дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

УБ хотын Захирагчийн ажлын албаны 2014 оны төсвийг нийслэлийн Төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой зарим хууль, журам, зааврын хэрэгжилт зарим талаар хангалтгүй байна.

УБ хотын Захирагчийн ажлын албаны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар УБ хотын Захирагчийн ажлын албаны 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар 4 аудитын хяналтын горим, 7 нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн. Уг бодлогын баримт бичигтэй бүртгэлийн програм уялдсан байна

УБ хотын Захирагчийн ажлын албаны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

УБ хотын Захирагчийн ажлын албаны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

УБ хотын Захирагчийн ажлын албаны дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад зарим талаар дотоод хяналт хангалтгүй байна.

6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу дүүргийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

УБ хотын Захирагчийн ажлын албаны төсвийн захирагч нь 2014 онд улсын төсвөөс урсгал зардалд 738,249.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 651,474.1 мянган төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 86,775.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна

УБ хотын Захирагчийн ажлын албаны төсвийн захирагч нь 2014 онд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 683,921.2 мянган, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс олгосон тусламжийн санхүүжилт 61,634.0 мянга, Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр үйл ажиллагааны болон хөрөнгийн санхүүжилт 853,735.0 мянга, төсөл хөтөлбөрийн санхүүжилт 83,750.3 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 9,062.0 мянга, төсөвт байгууллагын урамшуулалд 18,256.9 мянга, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст 200700947 тоот улсын тэмдэгтийн хураамжийн орлого төвлөрүүлэх тусгай данс нээлгэн төвлөрүүлсэн орлого 1,533,000.0 мянга, нийт 3,243,359.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан байна.

Улсын төсвөөс урсгал зардалд 1,354,824.5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,248,858.4 мянган төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 105,966.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

7. Шилэн дансны мэдээлэл

Тус байгууллага нь <http://shilendans.gov.mn/> сайтад өөрийн нууц үгээр нэвтэрч байгууллагын 2015 оны 1 дүгээр сарын төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулсан байна.

8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Орлого, зардлыг дутуу тайлагнасан, унааны хөнгөлөлт илүү олгосон, төсвийн зардлыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан, эд хөрөнгийн тооллогыг чанартай хийгээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр эрсдлүүд нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулах, төсвийн зориулалт зөрчих, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, төсвийн сахилга батыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

УБ хотын Захирагчийн ажлын албаны төсвийн захирагч байгууллагын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 1,132,311.8 мянган төгрөгийн санхүүжилт болон бусад орлого, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, тээвэр шатахуун, гэрэл цахилгаан зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 34.9 хувь, нийт зардлын 34,9 хувь, нийт хөрөнгийн 26.0 хувийг тус тус эзэлж байна.

10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Он удаан жил болсон 45,083.1 мянган төгрөгийн авлага (*Багахангай мах боловсруулах үйлдвэрт 2001 онд нийслэлийн хүн амын хэрэгцээнд мах нөөцөлж бэлтгэх, махны хомсдол, үнийн хөөрөгдлийг багасгах зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн үндсэн төлбөр болон зээлийн хүүгийн авлага 45,083.1 мянга*), 12,309.9 мянган төгрөгийн өглөгийн (*Сангийн яаманд төлөх махны зээлийн хүүгийн өр 9,822.3 мянга, Сангийн яам Эс-Жи-Групп ХХК-ний хоорондын тооцооноос үлдсэн 2,487.5 мянга*) үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл "*Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх ... 6.4.8. төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*" заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Он удаан жил болсон өр, авлагыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авах зөвлөмж өглөө.

11. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Хууль, журам мөрдөөгүйгээс гарсан 57,393.0 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй бөгөөд цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

УБ хотын Захирагчийн ажлын албаны 2014 оны санхүүгийн тайланд аудит хийж буй цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 2014 оны жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгөнд биет тест хийгээгүй. Иймд 2015 оны санхүүгийн тайланд хийх завсрын аудитаар бараа материал, үндсэн хөрөнгөнд биет тест хийх ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

УБ хотын Захирагчийн ажлын албаны 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 91,566.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба дахин давтахгүй байх зөвлөмж өглөө.

15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар 6 зөвлөмж өгсөнөөс 4-ыг бүрэн хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

16. Зөрчилгүй санал дүгнэлт:


УБ хотын Захирагчийн ажлын албаны 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 11 хуудас, менежментийн захидал 3 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДЭД ДАРГА



Т.САРАНТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ЭНХДАЛАЙ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



Б.МӨНХБАТ

2015.03.31

УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Авлага, өглөг.....	3

Менежментийн захидал

Нийслэлийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг УБ хотын Захирагчийн ажлын албаны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Нийслэлийн аудитын газар та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан УБ хотын Захирагчийн ажлын албаны санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1: Санхүүгийн тайлан
НАГ-ын ажиглалт**

**Тэргүүлэх ач холбогдол №1
НАГ-ын зөвлөмж**

Он удаан жил болсон 45,083.1 мянган төгрөгийн авлага (Багахангай мах боловсруулах үйлдвэрт 2001 онд нийслэлийн хүн амын хэрэгцээнд мах нөөцөлж бэлтгэх, махны хомсдол, үнийн хөөрөгдлийг багасгах зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн үндсэн төлбөр болон зээлийн хүүгийн авлага 45,083.1 мянга), 12,309.9 мянган төгрөгийн өглөгийн (Сангийн яаманд төлөх махны зээлийн хүүгийн өр 9,822.3 мянга, Сангийн яам Эс-Жи-Групп ХХК-ний хоорондын тооцооноос үлдсэн 2,487.5 мянга) үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл "Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх ... 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг зөрчиж байна.

- Он удаан жил болсон өр, авлагыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

Эрсдэлүүд

- Өр, авлагыг буруу тооцох;
- Холбогдох хууль, журам, зааврын холбогдох заалт хэрэгжихгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Зөрчлийг хүлээн зөвшөөрч цаашид анхаарах талаар хариу ирүүлсэн.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДЭД ДАРГА

Т.САРАНТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.МӨНХБАТ

2015.03.16

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА
2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Байгууллагаас ирүүлсэн менежментийн захидлын хариу



УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ц Жигжиджавын гудамж 9, Хангарьд ордон,
Утас/Факс: (976-11) 31-53-47, <http://www.ubservice.mn>

2015.03.18, № 01/269
танай _____-ны № 301 -т

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Т. Сэринтуяаг
У. Оюун
18/15

Менежментийн захидлын хариу
хүргүүлэх тухай

Тус албаны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн аудитын шалгалтыг шуурхай хийж гүйцэтгэсэн санхүүгийн багийнханд талархал илэрхийлье.

Танай байгууллагаас шалгалтын явцад ирүүлсэн менежментийн захидалд дурьдсан асуудалтай санал нэгтэй байна.

Иймд байгууллагын урсгал санхүүгийн ажлыг хууль журмын дагуу зөв зохион байгуулж ажиллахын зэрэгцээ дээрх зөрчилтэй асуудалд анхааран цаашид дахин давтан гаргахгүй хяналт тавьж, хамтран ажиллах болно.



ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Б.БАДРАЛ

1110300612

**УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА
2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
НИЙТ ХӨРӨНГӨ			
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	57,730,496.83	85,194,764.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,869.03	-
3101	Кассанд байгаа бэлэн мөнгө	2,869.02	-
310101	Төгрөг\ ЖМС	2,869.02	-
3102	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.01	-
310201	Төгрөг	0.01	-
31020103	Төсөвт байгууллагын харилцах	0.01	-
33	АВЛАГА	45,140,917.00	61,787,108.00
3304	Зээлийн хүүгийн авлага	45,140,917.00	45,083,108.00
3305	Бусад авлага	-	16,704,000.00
330501	Байгууллагаас авах авлага	-	16,704,000.00
33050110	Бусад зардлын тооцооны авлага	-	16,704,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,586,710.80	23,407,656.70
3501	Түүхий эд материал	2,364,120.00	934,670.00
350101	Тусгай зориулалттай материал	2,364,120.00	934,670.00
3504	Хангамжийн материал	10,222,590.80	22,472,986.70
350401	Бичиг хэргийн материал	1,899,849.80	1,485,248.70
350402	Аж ахуйн материал	8,322,741.00	20,987,738.00
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	57,730,496.83	85,194,764.70
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	112,015,143.54	175,254,023.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	112,015,143.54	175,254,023.53
3902	Биет хөрөнгө	111,792,226.98	175,102,773.48
390203	Машин тоног төхөөрөмж(компьютер)	47,921,582.74	60,419,314.06
39020301	Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	165,358,505.09	167,684,840.30
39020302	Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(117,436,922.35)	(107,265,526.24)
390204	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,864,042.99	47,794,652.82
39020401	Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	119,262,319.80	105,180,786.19
39020402	Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(61,398,276.81)	(57,386,133.37)
390208	Бусад үндсэн хөрөнгө	6,006,601.25	66,888,806.60
3902080102	Бусад үндсэн хөрөнгө	10,486,650.00	75,609,803.00
39020802	Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(4,480,048.75)	(8,720,996.40)
3903	Биет бус хөрөнгө	222,916.56	151,250.05
390301	Програм хангамж	222,916.56	151,250.05
39030101	Програм хангамж - Анхны өртөг	19,617,500.00	19,617,500.00
39030102	Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(19,394,583.44)	(19,466,249.95)

**УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА
2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	112,015,143.54	175,254,023.53
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	169,745,640.37	260,448,788.23
	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,309,876.00	29,009,876.00
4103	өглөг	12,309,876.00	29,009,876.00
410305	Зээлийн хүүгийн тооцоо	12,309,876.00	12,309,876.00
410306	Бусад өглөг	-	16,700,000.00
41030601	Байгууллагад төлөх өглөг	-	16,700,000.00
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	12,309,876.00	29,009,876.00
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	12,309,876.00	29,009,876.00
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧ	-	-
5101	Засгийн газрын сан	290,541,729.80	290,541,729.80
5103	Хуримтлагдсан үр дүн	(143,357,804.16)	(68,388,979.16)
510301	Өмнөх үеийн үр дүн	(143,357,804.16)	(142,392,127.02)
510302	Тайлант үеийн үр дүн	-	74,003,147.86
5104	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,251,838.73	9,286,161.59
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	157,435,764.37	231,438,912.23
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	169,745,640.37	260,448,788.23

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,152,657,897.00	1,683,040,463.20
1303	Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	2,152,657,897.00	1,683,040,463.20
130301	Улсын төвлөрсөн төсвөөс	-	145,384,329.20
13030104	Төсвийн хуваарилаагүй зардал	-	61,634,000.00
13030105	Хөрөнгийн	-	83,750,329.20
130302	Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	2,152,657,897.00	1,537,656,134.00
13030201	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	677,601,800.00	683,921,200.00
13030204	Төсвийн хуваарилаагүй зардал	1,475,056,097.00	853,734,934.00
14	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,222,506.84	42,318,904.55
1402	Бараа, үйлчилгээний борлуулалт	16,222,506.84	42,318,904.55
140201	Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	16,222,506.84	42,318,904.55
14020101	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	7,561,980.26
14020102	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	15,192,506.84	-